

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-21</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>22-45</i>
<hr/>	
<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	<i>22-22</i>
<i>2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>22-45</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 12 дугаар
сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны
товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 39 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ц.Туваан, Ц.Идэрбат;

Чөлөөтэй: С.Ганбаатар, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, мөн газрын мэргэжилтэн Э.Баяртулга, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Нинж, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал

хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Сарангэрэл танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 2, 3, 4, 5, 6, 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ж.Чинбүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Сарангэрэл, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, мөн яамны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунт нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 1, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, П.Анужин, Ж.Чинбүрэн, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хүчин зүйл, халдварт болон халдварт бус өвчнийг тандах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах” гэснийг “хүчин зүйлийг, тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хууль” гэсний дараа “Үндэсний аюулгүй байдлын тухай” гэж, “Эрүүл ахуйн тухай хууль,” гэсний дараа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” гэж нэмж, мөн хэсгийн “Боловсролын тухай” гэснийг “Боловсролын ерөнхий” гэж өөрчилж, 2.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Сарангэрэл нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “өвчний шинж тэмдэг илрээгүй хүн амыг” гэснийг “хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан, өвчин эмгэгээс” гэж тус тус өөрчилж, 3.1.3, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3. “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” гэж хүний болон зоонозын халдварт өвчний дэгдэлт, шалтгаан тодорхойгүй өвчлөл, өвчлөлийн шинэ тохиолдол, хими, цацрагийн осол, хордлогод хүн ам өртсөн, эсхүл өртөх нөхцөл үүссэнийг;

3.1.4. “эрүүл мэндийг дэмжих” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.19-д заасныг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “чанар, тоон үзүүлэлт судалгааны аргаар” гэснийг, 3.1.13 дахь заалтын “арга барилд сургах” гэснийг, 3.1.8, 3.1.19, 3.1.21 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.17 дахь заалтын “эрүүл мэндийн их дээд сургуулийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн мэргэжилтнийг” гэснийг “их, дээд сургууль, коллежийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн, тухайн мэргэжлээрээ энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад ажиллаж байгаа ажилтныг” гэж, 3.1.18 дахь заалтын “ажилтан” гэснийг “мэргэжилтэн” гэж, “энэ хуулийн 7.1.1-7.1.3-д заасан байгууллагад” гэснийг “их, дээд сургууль, коллежийг энэ хуулийн 3.1.15-д зааснаас бусад чиглэлээр төгсөж, энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад энэ хуулийн 5.2-5.9-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.16” гэж, 3.1.16 дахь заалтын “чиглэлээр ажилладаг бусад ажилтныг” гэснийг “бусад мэргэжилтнийг” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.17” гэж, 3.1.17 дахь заалтын дугаарыг “3.1.15” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүнд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендерийн тэгш байдлыг хангах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “гэр бүл төлөвлөлт,” гэснийг хасаж, 5.2.6 дахь заалтыг 5.7 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Энэ хуулийн 5.1.6-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хүрээнд хувь хүн, хосууд эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын байдалд тохируулан гэр бүл төлөвлөх, тэдний нөхөн үржихүйн эрхийг хамгаалах, мэдлэг олгох үйл ажиллагаа явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сэтгэл зүйн эрүүл мэнд” гэснийг “сэтгэц-зан үйл” гэж өөрчилж, 5.2.5 дахь заалтыг 5.6 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.6.Энэ хуулийн 5.1.5-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.6.1. нийгэм болон хүрээлэн байгаа орчноос үүдэлтэй сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах;

5.6.2. хүнийг амьдралын зөв хэв маягт сургах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “хөрсний бохирдол, ус хангамж, ариун цэвэр, хог хаягдлаас” гэснийг “уур амьсгалын өөрчлөлт, ус хангамж, хог хаягдал, хөрсний бохирдлоос” гэж, мөн заалтын дугаарыг “5.3” гэж тус тус өөрчилж, 5.2.4 дэх заалтыг 5.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.5.1. хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос урьдчилан сэргийлэх;

5.5.2. хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогод нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоох, тандалт, судалгаа хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1. халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олонд тулгуурлан зохион байгуулах;

5.2.2. нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын дугаарыг “5.4” гэж, мөн заалтын “өвчлөл,” гэсний дараа “осол, гэмтэл,” гэж нэмж, 5.2.8 дахь заалтын дугаарыг “5.9” гэж, мөн заалтын “байгалийн гамшиг, нийтийг хамарсан ноцтой байдлын үед” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэж, “бэлэн байдлыг хангах,” гэснийг “, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа явуулна.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтын “дэмжих,” гэсний дараа “хамгаалах” гэж нэмж, мөн заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох” гэснийг 5.10.3 дахь заалт болгон өөрчилж, 5.3.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

“5.11.Энэ хуулийн 5.10.3-г заасан чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгана.

5.12.Энэ хуулийн 5.11-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, эрх бүхий этгээдэд танилцуулахтай холбогдсон харилцааг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн гарчиг, 6.1-6.5, 6.10-6.12 дахь хэсгийг тус тус хасаж, 6.6 дахь хэсгийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл

6.1.Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий Нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

7.1.2. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг гамшгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг 8 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэг

8.1. Төрийн захиргааны төв байгууллагууд нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. хүн амын эрүүл мэндийг дэмжих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх;

8.1.2. энэ хуулийн 14.1.3-т заасан чиг үүрэг;

8.1.3. Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг бодлого, шийдвэртээ тусгаж, хэрэгжүүлэх.

8.2. Энэ хуулийн 8.1-д заасан арга хэмжээний биелэлтийн тайланг жил бүрийн хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалтын “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэсний өмнө “шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж нэмж, мөн заалтын дугаарыг “12.1.7” гэж өөрчилж, 6.8 дахь хэсгийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.8.1-6.8.2 дахь заалтын дугаарыг “9.1.1-9.1.2” гэж, 6.8.4 дэх заалтын дугаарыг “9.1.3” гэж тус тус өөрчлөх:

“9 дүгээр зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

9.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“9.1.4.нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжин ажиллаж байгаа байгууллагыг арга зүйгээр хангаж ажиллах;

9.1.5.Энэ хуулийн 8.2-т заасан тайланг нэгтгэн Зөвлөлд жил бүрийн дөрөвдүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг 10 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.13.1-6.13.4 дэх заалтын дугаарыг “10.1.1-10.1.4” гэж өөрчлөх:

“10 дугаар зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.13.2 дахь заалтын “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар” гэснийг “шаардлагатай санхүүжилтийг эрх бүхий байгууллагаар” гэж, 6.13.3 дахь заалтын “нөхцөлийг бүрдүүлэх” гэснийг “нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэж тус тус өөрчилж, 6.13.4 дэх заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа “, эрүүл мэндийн боловсрол олгох” гэж, мөн заалтын “оролцуулах” гэсний дараа “, урамшуулах” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“10.1.5.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл

мэндийн боловсрол олгох асуудлаар эрүүл мэндийн байгууллага, ажилтныг дэмжиж ажиллах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасныг үндэслэн” гэснийг, “эрх зүйн байдал,” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн дугаарыг “11.2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “7.1.2, 7.1.3-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын” гэснийг “11.1.2-т заасан байгууллагын” гэж, “батална” гэснийг “баталж, удирдлагыг Эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга томилж, чөлөөлнө” гэж тус тус өөрчилж, “дүрмийг” гэсний дараа “хүн амын төвлөрөл, газар нутгийн байршлыг харгалзан” гэж нэмж, мөн хэсгийн дугаарыг “11.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг 11.4 дэх хэсэг болгон, мөн хэсгийн “15.1.4, 15.1.7, 15.1.11-15.1.13-т” гэснийг “15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т” гэж, “нийгмийн эрүүл мэндийн” гэснийг “энэ хуулийн 11.1.3-т заасан” гэж тус тус өөрчилж, “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтныг ажиллуулж болно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“11.5. Энэ хуулийн 11.1.3-т заасан байгууллагын иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг 11.6 дахь хэсэг болгон “ажилтныг ажиллуулж болно” гэснийг “мэргэжилтэн ажиллуулна” гэж, 8.9 дэх хэсгийг 11.7 дахь хэсэг болгон мөн хэсгийн “7.1.1-7.1.5-д” гэснийг “11.1.1-11.1.4-т” гэж, “хоол зүйчид нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ” гэснийг “хоол зүйч нарыг мэргэжил, арга зүйгээр хангана” гэж тус тус өөрчилж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай 11.8, 11.9 дэх хэсэг нэмэх:

“11.8.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасан байгууллага нь энэ хуулийн 11.1.4-т заасан нэгж, албыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.”

11.9.Энэ хуулийн 5.10.1, 5.10.2, 5.10.3, 5.10.4-т заасан тусламж, үйлчилгээг хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

27. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бодлого стратеги” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэл” гэж өөрчилж, “мэргэжил, удирдлага, арга зүйгээр хангах” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.1.2.энэ хуулийн 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5-д заасан байгууллага, нэгж, алба болон нийгмийн эрүүл мэндийн ажилтныг мэргэжил, арга зүйгээр хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “өвчний хяналт, сэргийлэлтийн” гэснийг “энэ хуулийн 5.2-5.9-д заасан” гэж, “удирдан зохион байгуулах” гэснийг “зохион байгуулах, хянах, мэдээлэх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэж тус тус өөрчилж, 8.1.3 дахь заалтыг, 8.1.4 дэх заалтын “хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох,” гэснийг, мөн заалтын “, сургагч багш бэлтгэх, мэргэжил арга зүйгээр хангах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

29. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэснийг

“үндэсний хэмжээний судалгаа хийх, зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах” гэж, 8.1.6 дахь заалтын “чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх” гэснийг “үндэсний хэмжээний лавлагаа лабораторитой байх” гэж, 8.1.7 дахь заалтын “урьдчилан сэргийлэх тарилга, биобэлдмэлийг” гэснийг “бүтээгдэхүүнийг” гэж, 8.1.8 дахь заалтын “чиглэлээр ажиллаж байгаа ажилтныг сургах, чадавхжуулах” гэснийг “ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах” гэж, 8.1.9 дэх заалтын “мэдээллийн санг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх” гэснийг “мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох, эмхэтгэн түгээх, эргэн мэдээлэх” гэж тус тус өөрчлөх хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.4.1 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтын “бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар” гэж, 8.2.7 дахь заалтын “аюулгүй байдал алдагдахаас” гэснийг “аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос” гэж тус тус өөрчилж, 8.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.2.2.хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх орчны хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, хянах, холбогдох арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөн зохион байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэсний өмнө “шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж нэмж, 8.2.5 дахь заалтын “зонхилон тохиолдох” гэснийг, мөн заалтын “, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, мэдээлэх, хянах” гэснийг, 8.2.8 дахь заалтын “өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх,” гэснийг, мөн заалтын “, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх” гэснийг, 8.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

33. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.2.7.сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

12.2.8. нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт, үнэлгээ хийх;

12.2.9. нийгмийн эрүүл мэндийн лабораторийн үйл ажиллагаа эрхлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

34. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.4.3 дахь заалтын “халдварт болон халдварт бус зонхилон тохиолдох өвчний” гэснийг, 8.4.4 дэх заалтыг тус тус хасах:

“12.3.1.дархлаажуулалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

12.3.2.өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

35. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалтын “хүний эрүүл мэндэд” гэснийг “харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд” гэж, “зан үйл, эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах,” гэснийг “эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх,” гэж өөрчилж, 8.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

36. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“12.4. Энэ хуулийн 11.1.4-т заасан нэгж, алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.4.1.тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтанд нийгмийн эрүүл мэндийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

12.4.2. тухайн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн чиглэлээр тандалт, судалгаа хийх;

12.4.3. тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

37. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.1 дэх заалтыг, 9.1.3 дахь заалтын “халдварт болон халдварт бус зонхилон тохиолдох өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх,” гэснийг тус тус хасаж, 9.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.3.нийгмийн эрүүл мэндийн асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтанд хандах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

38. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“13.2.2.гэр бүл, хамт олны дунд эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг бий болгоход нөлөөлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

39. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “тархвар судлалд” гэснийг “тандалт, судалгаа, тархвар судлалын асуумжид” гэж, 9.2.6 дахь заалтын “нөлөөллийн талаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад мэдээлэх” гэснийг “нөлөөлөл, сэжигтэй тохиолдлын талаарх мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэх” гэж тус тус өөрчилж, 9.2.2 дахь заалтын “, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх дадал хандлагатай байх” гэснийг, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

40. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “зөвлөгөө” гэсний дараа “, мэдээлэл” гэж нэмж, мөн заалтын “хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай” гэснийг “дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай” гэж өөрчилж, 10.1.3, 10.1.5, 10.1.7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

41. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “орчин бүрдүүлэх” гэсний дараа “асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган, хэрэгжүүлэх” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“14.1.5.байгууллагын үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн онцлогт уялдуулан ажилтныг дархлаажуулалтад хамруулах арга хэмжээ авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

42. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг 11.10 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.10.Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, боловсролын сургалтын байгууллагад нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

43. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл. Олон нийтийн оролцоо

15.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нээлттэй ил тод байх бөгөөд түүнд олон нийтийн оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

15.2. Энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

15.2.1. байнгын ажиллагаатай цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх, санал авах;

15.2.2. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын сайн дурын оролцоог хангах, урамшуулах.

15.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

44. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3 дахь хэсгийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээлэл хүргэнэ.

16.2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй түгээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

45. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1.1, 28.1.4, 28.1.5-д заасан эрх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

46. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах,” гэснийг хасаж, мөн заалтын “дэмжлэг үзүүлэх” гэсний дараа “, мэргэжлийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд зааварчилгаа, зөвлөгөө өгөх” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“17.2.5.хүн амын эрүүл мэндэд аюул бүхий өвчин, хордлого, орчны сөрөг нөлөөллийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

47. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “ажилтан” гэсний дараа “энэ хууль болон” гэж нэмж, 14.2 дахь хэсгийн “нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

48. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.4 дэх хэсгийг хасах:

“19.1.Энэ хуулийн 19.2-т зааснаас бусад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

19.2.Холбогдох хуульд заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын болон Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

49. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, 15.5 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээний” гэсний дараа “төрөл” гэж нэмэх:

“19.4.Нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

50. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Иргэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хуулийн этгээд нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны талаар, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар” гэж өөрчилж, 16.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

51. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “гэмт хэргийн шинжгүй” гэснийг “хуульд өөрөөр заагаагүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

52. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Энэ хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

53. Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмэх, хасах саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

П.Анужин: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа, 5.2.3 дахь заалтын “хадгалах” гэсний дараа, 5.2.7 дахь заалтын “тандах” гэсний дараа “үйл ажиллагаа явуулна.” гэж, 6 дугаар зүйлийн 6.13.3 дахь заалтын “нутаг дэвсгэрийн” гэсний өмнө “харьяа” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.4, 8.4.5 дахь заалтын “ноцтой байдлын” гэсний дараа “үеийн” гэж, “арга хэмжээг” гэсний дараа “авч” гэж, 8.2.8 дахь заалтын “эрүүл мэндийн” гэсний өмнө “хүн амд” гэж, 8.9 дэх хэсгийн

“боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “батална” гэсний өмнө “хамтран” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн байдал” гэснийг “эрүүл мэнд” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “нөлөөлөх” гэснийг “үзүүлэх” гэж, “хариу арга хэмжээг” гэснийг “холбогдох арга хэмжээ” гэж, 3.1.7 дахь заалтын “тодорхойлж” гэснийг “тогтоож” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “олон хувилбартай байх” гэснийг “хэлбэр үл харгалзах” гэж, 4.1.7 дахь заалтыг “олон нийтийн, сайн дурын ажилтны оролцоог хангах” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.3, 5.2.7, 5.2.8 дахь заалтын “төрөлд” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд” гэж, 5.2.2 дахь заалтын “өвчлөл” гэснийг “өвчин эмгэг” гэж, 5.3.1 дэх заалтын “тандалт, судалгаа” гэснийг “тандах, судлах” гэж, 5.3.5 дахь заалтын “түншлэл, хамтын ажиллагаа” гэснийг “оролцоо, хамтын ажиллагааг хангах” гэж, 6 дугаар зүйлийн 6.8.2 дахь заалтын “бодлого, хөгжлийн чиг хандлага,” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэлийг болон” гэж, “тодорхойлох” гэснийг “тодорхойлж, хэрэгжүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.4 дэх хэсгийн “эрх үүргийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 8.2.7 дахь заалтын “тодорхойлох” гэснийг “тогтоох” гэж, 8.4.3 дахь заалтын “зохион байгуулах” гэснийг “зохион байгуулж, хэрэгжүүлэх” гэж, 8.4.5 дахь заалтын “бэлэн байдал” гэснийг “бэлэн байдлыг хангах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хуулийн” гэснийг “хууль тогтоомжийн” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “боломж бүрдүүлэх” гэснийг “боломжоор хангах” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрхтэй” гэснийг “эрх эдэлнэ” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “ажилтанд урамшуулал олгох” гэснийг “ажилтныг урамшуулах” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “ангилал,” гэснийг “ангиллаар болон” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль эрх зүйн” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын “хөдөлмөр эрхлэгч” гэснийг, 5.2.7 дахь заалтын “судлах,” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.4, 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “амьдрах” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.13.4, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “нийгмийн” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “, мэдлэг” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “энэ хуулийн 3.1.11-д заасан” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “арга болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

1.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

II.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, 1 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.26 дахь заалт нэмсүгэй:

“3.1.26.“нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.17-д заасан мэргэжилтнийг.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “29.5 дахь” гэсний өмнө “29.2 дахь хэсгийн “эмнэлгийн мэргэжилтэн,” гэсний дараа “нийгмийн эрүүл мэндийн ажилтан,” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх хэсэгт “нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, арга хэмжээ болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэж” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.6.4.хуульд өөрөөр заагаагүй бол нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэндийн тухай хууль тогтоомж” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” гэж өөрчилж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийн “энэ хууль” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “13 дугаар” гэсний өмнө “7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд шинэ зүйл нэмсэнтэй уялдуулан төслийн дугаарлалтыг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.29 дэх хэсгийг” гэснийг “6.31 дэх зүйл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.8 дугаар зүйлийн “6.28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэсний дараа “6.29 дүгээр зүйл,” гэснийг 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг,” гэсний өмнө “6.31 дүгээр зүйл,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “нийтийг хамарсан халдварт өвчний” гэснийг хасаж, “нийгмийн эрүүл мэндийн” гэсний өмнө “дэгдэлт,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, 17 гишүүнээс 11 гишүүн ирж, 64.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 12 цаг 39 минут

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Анужин: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52,9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Баярсайхан гишүүн, Бейсен гишүүн, Жаргалмаа гишүүн, Сандаг-Очир гишүүн, Сарангэрэл гишүүн, Саранчимэг гишүүн, Одонтуяа гишүүн, Чинбүрэн гишүүн, Чинзориг нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

1 дүгээрт. Байнгын хорооны тогтоол батлах тухай. Цаглавар батална.

2 дугаарт Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. Уг хуулийг Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүд байна уу. Байхгүй хэлэлцэх асуудалдаа оръё.

2023 оны 12 дугаар сарын сард Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглаврыг баталъя.

Та бүхэнд тогтоолын төслийг урьдчилаад тараасан байгаа. Байнгын хорооны цаглавартай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй бүгдээрээ цаглавраа баталъя.

Байнгын хорооны цаглаврын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 80 хувиар Байнгын хорооны цаглавар дэмжигдлээ.

12.40 цаг.

Хэлэлцэх асуудлынхаа 2 дугаарт оръё. Цаглавар баталсантай холбогдуулж хэлэхэд манай Нийгмийн бодлогын байнгын хороо үргэлж ирц өндөртэй, ямар нэгэн ирц хүрэхгүйгээс болж нэг ч удаагийн хурал хойшлогдож болон тасалж байгаагүй. Бүх хуралдаан цагтаа явагддаг. Өнөөдөр болсон хамтарсан Байнгын хорооны хурал дээр ч гэсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ цагтаа хүрэлцэн ирж, хуралдаа үргэлж идэвхтэй оролцдогт талархаж байгаагаа илэрхийлье ээ.

Хэлэлцэх асуудал. Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийе ээ.

Ажлын хэсгийг та бүхэндээ танилцуулъя. Ажлын хэсгийг хуралдааны танхимд орж ирэхийг урьж байна. Баярболд Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга, Өнөрсайхан Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, Цэрэнчунт Эрүүл мэндийн яамны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Баяртулга Эрүүл мэндийн яамны нийтийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, Нинжэ Эрүүл мэндийн

яамны бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл таныг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг хийхийг микрофонд урьж байна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 14 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, ажлын хэсгийн гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Анужин, Чинбүрэн, Жаргалмаа, Оюунчимэг нар ажиллалаа.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх дэд ажлын хэсгийг мөн байгуулан ажилласан. Ажлын хэсэг болон ажлын дэд хэсэг өнгөрсөн хугацаанд нийт 19 удаа хуралдлаа.

Мөн Дархан-Уул аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төв, Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газарт очиж ажиллан тухайн салбарт ажиллаж байгаа ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулж, хуулийн төсөлтэй холбогдуулан санал авсан болно.

Түүнчлэн хуулийн төслийг Үндсэн хууль болон бусад хуультай нийцүүлэх, зүйл заалт хоорондын нийцлийг хангах, хуулийн төслийн бүтцийг Хууль тогтоомжийн тухай хуультай нийцүүлж өөрчлөхтэй холбогдуулан санал боловсруулах D-parliament-аар ирүүлсэн саналуудыг хэлэлцэх,

мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачидтай уулзах зэрэг ажлыг гүйцэтгэлээ.

Дээр дурдсан ажлын үр дүнд үндэслэн ажлын хэсгээс бэлтгэсэн 52 зарчмын, 3 багц найруулгын хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар 10 зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэлээ. Үүнд:

1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зарчимд зарим асуудлыг нэмж тусгах,

2.Хуулийн төслийн бүтцийг зөв хэлбэрт оруулах,

3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тогтолцоог тодорхой болгож, хэрэгжүүлэх чиг үүргийг оновчтой болгох,

4.Нийгмийн эрүүл мэндийн ажилтны баталгааг Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрүүл мэндийн мэргэжилтэнтэй адилтгах,

5.Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх ,

6.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг анхан шатаас тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлэх зэрэг асуудлыг тусгасан болно.

Саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхнийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

А.Анужин: Ажлын хэсгийн даргын танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу. Батсүхийн Саранчимэг гишүүн ажлын хэсгийн даргын танилцуулгатай холбоотойгоор асуулт асууна.

Б.Саранчимэг: Тэгэхээр бид Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох бодлого барьж байгаа. Тэгэхээр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийж байгаа. Тэгэхээр хуулийн төсөлтэй холбогдуулж тодруулах зүйл байгаа юм. Салбарын сайд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж хэлж байсан. Тэгэхээр үүнтэй холбоотой тодруулахад хуулийн төсөлд өрхийн эмнэлэг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ гэж нийгмийн эрүүл мэндийн ажилтныг ажиллахаар заасан байгаа өрхийн эмнэлэг дээр. Тэгэхээр өрхийн эмнэлгүүд маань эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувийн хэвилийн эрүүл мэндийн байгууллага байгаа. Тэгэхээр өрхийн эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүгийн тогтолцоо их тодорхой болж чадсан уу хуулиар.

Дараагийн асуудал хуулийн төсөлд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал гэсэн ийм томъёолол орж ирсэн байгаа. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрх, үүрэгт 8.2.4 т эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал хариу арга хэмжээ авах, хэрэгжүүлэх гэж орсон байгаа. Тэгэхээр бид ковидын 2 жилийн хугацаанд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд байсан гэж үзэж байна. Тэгэхээр цар тахлаас иргэдээ хамгаалах, мөн халдвараас урьдчилан сэргийлэхэд нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн хариу авах арга хэмжээ нэлээн их гүйцэтгэсэн. Тэгээд дээр ч гэсэн нэлээн туршилага суусан гэж харж байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөлд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээний талаарх зохицуулалт туссан байгаа юу. Энэ дээр нэг тодруулга авах гэсэн юм. Баярлалаа.

П.Анужин: Саранчимэг гишүүний 2 асуултад Эрүүл мэндийн сайд Чинзориг хариулъя.

С.Чинзориг: Бид Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг Засгийн газар өргөн бариад хэлэлцүүлж байна. Ер нь Эрүүл мэндийн тухай хуулиараа ч тэр, иргэний эрүүл мэндийг хамгаална гэдэг бол 2 талтай асуудал. Нэг тал нь нийгмийн эрүүл мэнд, нөгөө тал нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудал. Ний нуугүй хэлэхэд бид нар сүүлийн жилүүдэд нийгмийн эрүүл мэндийн асуудлыг жаахан орхигдуулаад, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчилсөн хойно нь эмчлэх гэдэг тал дээр нь илүү анхаарч ирсэн байна гэж бид үзэж байгаа. Нөгөө талдаа бусад улс орнуудын туршилага ч гэсэн тийм байна. Нийгмийн эрүүл мэнд, анхан шатын тусламж үйлчилгээндээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чинь дийлэнх нь үзүүлдэг. Санхүүжилтийнхээ 50-70 хувийг нь нийгмийн эрүүл мэнд, анхан шатын тусламж үйлчилгээндээ үзүүлдэг. Манайх үүнийхээ урвуу болчихоод байгаа юм. Бид нийгмийн эрүүл мэнд, анхан шатын тусламж үйлчилгээндээ санхүүжилтийнхээ дөнгөж 20 хувийг л өгч байна шүү дээ. Тэгэхээр бол олон улсын хөгжлийн жишгийн урвуу болчихоод байгаа. Энийгээ бид өөрчилж байна. Нийгмийн эрүүл мэнд тусламж, үйлчилгээ бол иргэний эрүүл мэндийг хамгаалах асуудлын тэргүүлэх чиглэл байх нь ёстой гээд эрүүл мэндийн салбарын шууд харилцааг зохицуулагч, эрүүл мэндийн салбарт анхдагч хууль болох Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг оруулж ирж байгаа юм. Энэ хууль орж ирж байгаа гол концепц нь эрүүл нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлдэг болгоё оо гэсэн ийм концепц л орж ирж байгаа юм. Одоогийн бид үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн аргаар даатгалын сангаас нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлнэ гэхээр өвчний тандалт, сэргийлэлт хяналтын асуудал нэлээн орхигдох, юм гарсан хойно л бид араас нь хөөх ийм юм руу яваад байгаа. Тийм

учраас нийгмийн эрүүл мэндийн тус тусламж, үйлчилгээг Улсын төсвөөс санхүүжүүлдэг байя. Харин эмнэлгийн тусламж, үйлчилгээгээ даатгалын сангаасаа тэр гүйцэтгэлийнхээ аргаараа санхүүжүүлдэг байя гэдэг ийм концепц үндсэн гол концепц нь ингэж орж ирж байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

2 дахь асуудал нь нийгмийн ноцтой байдлын хариу арга хэмжээ гэсэн асуудал бол энэ хуульд нэлээн голлох байр суурийг эзэлж байгаа. Саяын бид 3 жилийн ковидын цаг үед бидэнд асар том сургамж өглөө гэж бодож байна. Бид нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлж байж аливаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэр хяналт, тандалт, сэргийлэлттэй холбоотой асуудлыг гол бодлого болгож авч явбал ийм ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх ийм нөхцөл боломж бүрдэх юм байна гэсэн ийм асуудлаар хуульд оруулж ирж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье ээ. Тэгэхээр ковидын үеийн нөхцөл байдал бидэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульчлах, ийм тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл болгож хөгжүүлэхийг бидэнд нэлээн том сануулга өгсөн гэж бодож байгаа. Тийм учраас тэр өөрийн чинь хэлээд байгаа 8 дугаар бүлэг дээр ноцтой байдлын үед хариу арга хэмжээ авах гээд ингээд нэлээн том бүтэц бүлэг орж ирж байгаа. Энэ асуудал бол манай хуулийн гол амин сүнс нь байгаа юм гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Тэгээд манай мэргэжлийн хүмүүс, газрын дарга эд нар нэмэлт тайлбар хэлэх юм байвал хэлж болно.

П.Анужин: Асуултад гүйцээж хариулъя. 4 номерын микрофонд Баярболд дарга асуултад хариулъя. 4 номерын микрофоныг нээж өгье.

Д.Баярболд: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Саранчимэг гишүүний асуултад хариулъя. Нийгмийн эрүүл

мэндийн ноцтой байдлын үеийн асуудлыг хуульд эрүүл мэндийн тогтолцооны бүх үе шатад тодорхойлж авч үзсэн байгаа. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуулийн зорилт хэсэгт халдварт болон халдварт өвчин нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээ авах асуудлыг зорилго оруулсан. Мөн эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын үүрэгт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тохиолдолд шилжиж ажиллаж байгаа байгууллагуудаа мэргэжлийн удирдлагаар хангах, мөн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, гамигийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээ авах, мэдээлэл солилцох, салбар дундын хамтын ажиллагааг хангах журмыг баталж хэрэгжүүлнэ гэдгээр орсон. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан төв байгууллага, мөн дүүрэг, орон нутагт ажиллах нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд шуурхай удирдлагын нэгж байгуулж, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжиж ажиллахаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

П.Анужин: Саранчимэг гишүүн тодруулъя.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр өрхийн эмнэлэг гэдэг өнөөдөр хамгийн анхан шатны үйлчилгээ үзүүлдэг, ард түмэнтэйгээ хамгийн илүү их ойр байдаг эмнэлэг байдаг. Тэгэхээр өрхийн эмнэлгүүдийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо илүү тодорхой болсон уу гэсэн нэг асуултад илүү тодорхой хариулж өгөөч.

П.Анужин: Эрүүл мэндийн сайд Чинзориг асуултад хариулна.

С.Чинзориг: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдвал ялангуяа анхан шатын нэгж, сумын эмнэлэг, өрхийн эмнэлгүүдэд дээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойгоор нэлээн тийм чиг үүрэг нэмэгдэнэ. Ялангуяа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгтэй холбоотой асуудлууд орж ирнэ. Дээр нь бидний яриад байгаа нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тэргүүлэх чиглэл болж байгаа иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх эд нар асуудлууд гээд энэ асуудлууд бол сумын эмнэлэг, өрхийн эмнэлгүүд дээр очно. Одоогийн даатгалаас орж байгаа санхүүжилтээр сумын эрүүл мэнд, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд нэг иргэнээр тооцох санхүүжилтээрээ санхүүжилт авч байгаа. Энэ нь бол явдгаар явна. Дээр нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хийгдэж байгаа ажлууд нь тэр улсын төсвөөс зохих хэмжээнийх нь санхүүжилт нь нийгмийн эрүүл мэндийн тусламж.../минут дуусав.

П.Анужин: Ажлын хэсгийн ахлагчийн танилцуулгатай холбоотойгоор гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно. Зарчмын зөрүүтэй саналын хүрээнд ажлын хэсгийн ахлагчаас мөн асуулт асууж болно гэсэн ийм дэгтэй байдаг.

Ажлын хэсгийн ахлагч сая танилцууллаа нийт 19 удаа хуралдсан гэж. Тэгээд нийгмийн эрүүл мэндийн шинж чанартай анхдагч хууль бол ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 19 удаа хуралдсан хэдий ч ажлын хэсгийн ахлагч маань өөрөө Эрүүл мэндийн сайд байсан хугацаанаасаа эхлүүлээд эрүүл

мэндийн анхдагч хууль боловсруулалт дээр анхаарч ажиллаж байсан учраас нэлээн нягт нямбай ажилласан, удаан хугацаанд боловсруулагдсан хууль. Ажлын хэсэг ч гэсэн дээр маш анхааралтай ингэж анхаарал тавьж ажилласан гэдгийг би санал хураалтын өмнө хэлэхийг хүсэж байна.

Гишүүд ээ, зарчмын зөрүүтэй ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналууд дээр санал хураалт явуулъя. Саналын өмнө мөн Одонтуяа дарга хуультай холбоотой нэлээд олон зарчмын зөрүүтэй саналууд орж ирсэн. Хуульд давхцаж туссан асуудлуудыг нэгтгээд, мөн нэмж орох зарчмын зөрүүтэй саналуудыг нэгтгэсэн байдлаар уншаад явна. Үүнийг Одонтуяа даргад танилцуулж харилцан ойлголцсон байгаа гэж ингэж ойлгож байгаа. Зарчмын зөрүүтэй саналаа явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Та бүхэнд уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хүчин зүйл, халдварт болон халдварт бус өвчнийг тандах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах” гэснийг “хүчин зүйлийг, тандах, судлах, үнэлэх, хариу арга хэмжээг авах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Анужин, Чинбүрэн, Жаргалмаа, Оюунчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ санал хураалт. Санал 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 1 санал гаргасан. Энэ санал дээр мөн Одонтуяа даргын гаргасан санал нэгтгэгдсэн байгаа гэдгийг хэлье. Уншиж танилцуулъя.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хууль” гэсний дараа “Үндэсний аюулгүй байдлын тухай” гэж, “Эрүүл ахуйн тухай хууль,” гэсний дараа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай,” гэж нэмж, мөн хэсгийн “Боловсролын тухай” гэснийг “Боловсролын ерөнхий” гэж өөрчилж, 2.3 дахь хэсгийг хасах. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тус санал 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. 2 дугаар хэсэг дээр Одонтуяа гишүүн тодруулж асууя гэж байна.

С.Одонтуяа: Энэ хууль орж ирээд, дараа нь Эрүүл мэндийн яам засаад, бид нар дор дороо засахаар ингээд жосоохон будилчихлаа. 2.3 дээр анх нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн нөхцөлд олон улсын эрүүл мэндийн дүрмийг чиглэл болгож ажиллана гэсэн заалтыг яагаад хасчихсан юм бол. Зүгээр Олон улсын байгууллага, сая тэр Дэлхийн эрүүл мэндийн байгууллага тэр Женевт байгаа хүмүүс яг энэ нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг хүмүүстэй надад коммент ирэхэд энэ уг нь их чухал яг Ковидын үеэр чинь энийгээ л барьдаг юм шүү дээ. Яагаад хасаж байгаа юм бол гэсэн. Энийг яагаад хассан юм бол.

П.Анужин: Ажлын хэсгийн дарга Сарангэрэл хариулъя.

Д.Сарангэрэл: Хуулийн төслийн анхны хэсэг дээр бол нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед олон улсын эрүүл мэндийн байгууллагын дүрмийг барьж ажиллана гэсэн ийм заалт байсан юм. Тэгээд манай ажлын хэсэгт Хууль зүйн яам хуулийн мэргэжилтнүүд байгаа юм. Тэгээд бид угаасаа олон улсын гэрээ дүрмийг хэрэгжүүлдэг учраас энд хуульдаа тэгж олон улсын дүрмийг тусгах ёсгүй. Олон улсын гэрээгээр угаасаа хийгдээд явдаг учраас энийг

хасах нь зүйтэй гэдэг ийм саналыг хэлээд, тэгээд бид нар хуулийн мэргэжлийн хүмүүс саналаа гаргасан учраас хасаад явсан. Энэ дээр манай Цэрэнчунт нэмэх үү.

П.Анужин: 5 номерын микрофонд Эрүүл мэндийн яамны хуулийн газрын мэргэжилтэн Цэрэнчунт гүйцээгээд хариулт өгье.

Э.Цэрэнчунт: Хариулт өгье. 2.3 дээр нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн нөхцөл олон улсын эрүүл мэндийн дүрмийг чиглэл болгож ажиллана гэж анх орж ирсэн байгаа. Олон улсын эрүүл мэндийн дүрэм нь Монгол Улсын Олон улсын гэрээ соёрхон баталсан гэрээнд албан ёсоор орохгүй байгаа учраас хууль дээр эшлэх боломжгүй болсон байгаа.

П.Анужин: Одонтуяа дарга санал нийлж байна уу. Тэгвэл 2 дугаар зүйл дээр бид нар санал хураалтыг явуулсан байгаа. Санал хураалтыг хүчинтэй хэвээр нь үлдээгээд, Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж санал хураалт явуулъя.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүн байна уу. Одонтуяа дарга санал хэлье.

С.Одонтуяа: Судалгааны үр дүн, нотолгоо гэж оруулмаар байх юм. Яагаад гэхээр нотолгоо гэдэг үгийг нь дарчихаар чинь бид нар ерөөсөө яг нотолгоон дээр л суурилж явдаг юм шүү дээ. Тэгэхээр судалгааны үр дүн, нотолгоо гээд л оруулмаар л байх юм. Үгүй ээ нотолгоог нь дарчихсан байгаа байхгүй юу. Тэгсэн хэр нь ажлын хэсэг дээр уг нь нотолгоонд гэснийг ажлын хэсгийнх дээр бол зөв байгаад нөгөө юун дээрээ дарчихсан юм болов уу.

П.Анужин: Тэгье. Баярболд дарга 4 номерын микрофонд хариулчихъя. Тодорхой хариулъя.

Д.Баярболд: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Нотолгоо гэдэг маань өөрөө судалгааны үр дүнгээр хэмжигдэх үзүүлэлт гэдэг утга учраас нотолгоо гэдэг үгээ хасаад, судалгааны үр дүн олгосон байгаа. Судалгааны үр дүнд үндэслэнэ гэсэн үг. Нотолгоо нь.

П.Анүжин: Одонтуяа дарга. Бид нар энийг ажлын хэсэг дээр ярьсан юм. Ажлын хэсгийн гишүүд ч гэсэн нотолгоо гэдэг үгийг авсны учрыг бид нар ярилцсан. Эрүүл мэндийн яам бас саяын хариултыг бидэнд өгсөн. Танд санал байна уу. Ажлын хэсгийн дарга санал гаргаж байна. Судалгааны үр дүн, нотолгоо гэдэг үг байх нь зөв юм гэж. Тэгэхээр судалгааны үр дүн, нотолгоо гэдэг хуучин орж ирсэн байдлаар нь төслийн анхны байдлаар үлдээе ээ гэсэн саналыг ажлын хэсгийн дарга санал гаргаж байна.

Тэгвэл ажлын хэсгийн даргын болон Одонтуяа дарга нарын гаргасан саналаар судалгаа, нотолгоо гэсэн томъёоллоор ахин санал хураалт явуулъя. Төслийн 3 дугаар зүйл дээр судалгааны үр дүн, нотолгоо гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

3 дугаар хэсэг дээр дараагийн зүйлүүд дээр санал хураалт явуулъя.

3.1.11 дэх заалтын “өвчний шинж тэмдэг илрээгүй хүн амыг” гэснийг “хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан өвчин эмгэгээс” гэж тус тус өөрчилж, 3.1.3, 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3.1.3. “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” гэж хүний болон зоонозын—халдварт өвчний дэгдэлт, шалтгаан тодорхойгүй өвчлөл, өвчлөлийн шинэ тохиолдол, хими, цацрагийн осол, хордлогод хүн ам өртсөн, эсхүл өртөх нөхцөл үүссэнийг;

3.1.4. “эрүүл мэндийг дэмжих” гэж Эрүүл мэндийн тухай

хуулийн 3.1.19-д заасныг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “чанар, тоон үзүүлэлт судалгааны аргаар” гэснийг, 3.1.13 дахь заалтын “арга барилд сургах” гэснийг, 3.1.8, 3.1.19, 3.1.21 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.17 дахь заалтын “эрүүл мэндийн их дээд сургуулийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн мэргэжилтнийг” гэснийг “их, дээд сургууль, коллежийг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн, тухайн мэргэжлээрээ энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад ажиллаж байгаа ажилтныг” гэж, 3.1.18 дахь заалтын “ажилтан” гэснийг “мэргэжилтэн” гэж, “энэ хуулийн 7.1.1-7.1.3-д заасан байгууллагад” гэснийг “их, дээд сургууль, коллежийг энэ хуулийн 3.1.15-д зааснаас бусад чиглэлээр төгсөж, энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллагад энэ хуулийн 5.2-5.9-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэн” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.16” гэж, 3.1.16 дахь заалтын “чиглэлээр ажилладаг бусад ажилтныг” гэснийг “бусад мэргэжилтнийг” гэж, мөн заалтын дугаарыг “3.1.17” гэж, 3.1.17 дахь заалтын дугаарыг “3.1.15” гэж, тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Одонтуяа дарга асуулт асууя.

С.Одонтуяа: 4.1.4 дээр төр, иргэн, хуулийн этгээдийн гэж байгаа юм. Тэгсэн хэр нь, тэр хамгийн ар талд төр, иргэн, аж ахуйн нэгж гээд ингээд 2 янзаар оруулчихсан юм. Тэгэхээр хуульдаа 1 л байгаад л ерөөсөө төр, иргэн, аж ахуйн нэгж гэдгээр нь явчихвал яасан юм бэ. Тэгэхгүй бол ингээд 2 ороод

хүмүүсийн толгой эргүүлээд байгаа юм .
4.1.4.

2 дугаарт 4.1.11 дээр урамишууллын тогтолцоотой байх гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь бид ингээд юу ч хамаагүй юм хийсэн юмыг нь ингээд урамишуулаад байх биш, хэрэгтэй юм хийх хөшүүрэг аягүй чухал байдаг юм. Тэгэхээр энийг урамишууллын тогтолцоотой байх биш, хөшүүрэгтэй байх гэдэг заалт оруулбал ямар вэ гэсэн нэг ийм. Дээрээс нь нэг 4.1.5 дээр нэг ийм заалт байгаа юм. Үндэсний онцлог уламжлалд суурилан олон улсын жишиг хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх гэгчихсэн. Тэгэхээр үндэсний онцлог уламжлал нь олон улсын жишигт нийцнэ гэж яг олон улсын хэллэгээрээ ч байхгүй л дээ. Тэгээд энийг хасвал яадаг юм доо гээд.

Тэгээд би бол өөрийнхөө саналыг ажлын хэсэгт өгөөд тусгуулчихсан. Энэ саналууд бол дандаа олон улсын байгууллагуудын мэргэжилтнүүдээс ирсэн саналыг би яриад байгаа юм. Тэгэхээр энийг нь та хэд нэг хараад өгөөч.

П.Анужин: Ажлын хэсэг. 4 номерын микрофонд Баярболд дарга хариулт өгье.

Д.Баярболд: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. 4.1.5 үндэсний онцлог уламжлалд суурилна гэдэг нь бид нар ялангуяа нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн боловсрол олгох асуудлыг монголчууд бол үндэсний маш том онцлогтой. Хүүхэддээ, гэр бүлдээ эрүүл мэндийн боловсрол, зөв дадал хэвшилд сургадаг. Энэ дээрээ бид нар суурилъя. Тухайлбал, бид нар урсгал усанд сүү дусаадаггүй. Хүүхдэд чөмөг идүүлдэггүй ч юм уу ийм уламжлалт аргууд байдаг. Энийгээ орчин үеийнхээ арга хэлбэртэй нийцүүлээд хөгжүүлье. Уламжлалт арга хэлбэрээ авч явах ёстой шүү гэдэг зарчим дээр тулгуурлаад оруулсан. Энэ дээр манай

уламжлалтын эмнэлгийн салбарынхан маш их санал өгсний дагуу үүнийг оруулсан байгаа.

4.1.11-ийн хувьд урамишууллын тогтолцоотой байх гэдгийг сүүлийн юунаас хассан байгаа. Одонтуяа даргын саналыг ажлын хэсэг хүлээж авч, найруулгын өөрчлөлт хийж нэр томъёог жигдэлье гэсэн саналыг хүлээж авч байна. Санал хураалт явуулъя. Уучлаарай зүйл заалтыг уншиж танилцуулаагүй юм байна. Санал хураалтыг цуцалъя.

Ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүнд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендерийн тэгш байдлыг хангах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр түрүүний нөгөө судалгааны үр дүн, нотолгоо гэж явах нь байна шүү. Ажлын хэсгийнхэн анхаараад засаарай. Түрүүний зассантайгаа ижилтэйгээ засна. Санал хураалт явуулъя гишүүд ээ. Төслийн 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Бейсен гишүүн, Одонтуяа нарын гишүүд асуулт асууна. Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Уучлаарай найруулгын санал. 5.1.3 дээр хөдөлмөрийн

эрүүл мэнд гэгчихсэн ер нь хөдөлмөрийн эрүүл мэнд гээд юм байдаггүй шүү дээ. Энийг ажлын байрны эрүүл мэнд гэвэл яадаг юм бол. Тэгж тодорхойлдог уу. Олон Улсын байгууллагынхан чинь болохоор ажлын байрны эрүүл мэнд гээд яваад байх юм.

П.Анужин: Одонтуяа даргын асуултад ажлын хэсэг хариулъя. Энийг мөн ажлын хэсгийн ахлагч Сарангэрэл яг ижил санал ажлын хэсэг хуралдах үед тавьж байсан. Хөдөлмөрийн эрүүл мэнд гэж юу вэ гэж. Асуултад хариулъя. 4 номерын микрофоныг нээж өгье.

Д.Баярболд: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Олон улсын юунд occupational health буюу хөдөлмөрийн эрүүл мэнд гэдгээрээ явдаг. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд ч гэсэн хөдөлмөрийн эрүүл мэнд гэдгээр явж байгаа. Хөдөлмөрийн эрүүл мэнд гэдэг дотор ажлын байранд тавигдах эрүүл ахуйн нөхцөлүүд өөрөө яг ороод явдаг. Ийм байгаа учраас яг Олон улсын хэллэгээрээ хөдөлмөрийн эрүүл мэнд гэдгээр явж байгаа.

П.Анужин: Яах вэ, олон улсын хэллэгээрээ гэж байгаа ч гэсэн ямар олон улсын хэллэгээр нь хэлж байгаа биш. Монгол хэлэнд орчуулснаар гэж хэлээч. Тэгэхдээ энэ чинь хөдөлмөрийн тухай хуультайгаа нийцүүлсэн юм байна шүү дээ. Гол нь ерөөсөө тэр юм байна. Хөдөлмөрийн тухай хуульд ийм томъёоллоор яваад байгаа юм байна гэдэг хариулт байна. Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ яах аргагүй эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн удирдлагын асуудал дээр ер нь Анагаахын их сургууль дээр хичээл орсон ч гэсэн эмчилгээний ангид нь дэлгэрэнгүй хичээл ордог юм. Бусад салбартай адилхан биш. Гэтэл яг халдварт өвчний халдвартын эмнэлэг, сүрьеэгийн эмнэлэг, нийгмийн халдварт өвчин гардаг бусад юман дээр

та нар клиниктэй ажилладаг улсуудыг оруулахгүй бол энэ заалт дээр зөвхөн эрүүл мэндийн чиглэлээр төгссөн гэдэг дээр эмчилгээний анги төгссөн гээд л оруулахгүй бол энэ чинь учир дутагдалтай болно. Клиникийн тодорхой боловсролтой байхгүй бол эмнэлгүүдийн доголдол дээр зарим эмнэлгүүд дээр чинь шүдний эмч юм уу, компьютерын чиглэлийн эхогийн эмч нар ингээд дарга хийж байна шүү дээ. Клиникийн тодорхой боловсрол байхгүй асуудал гардаг байхгүй юу. Тийм учраас дээр эмчилгээний гээд оруулбал зөв юм шиг байна. Эрүүл мэнд эмчилгээний чиглэлээр гээд.

П.Анужин: Бейсен гишүүний асууж байгаа асуулт санал хураалт явуулчихсан 3 дугаар зүйлтэй холбоотой зүйлийг хэлж байна. Бид нар 3 дугаар зүйл дээр Бейсен гишүүнээс санал хураалт явуулсан. Одоо бид нар төслийн 5 дугаар зүйлийг яриад явж байна. 5 дугаар зүйл дээр Одонтуяа гишүүн санал оруулсан. Хариулт авсан. 5 дугаар зүйлийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “гэр бүл төлөвлөлт,” гэснийг хасаж, 5.2.6 дахь заалтыг 5.7 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Энэ хуулийн 5.1.6-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хүрээнд хувь хүн, хосууд эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын байдалд тохируулан гэр бүл төлөвлөх, тэдний нөхөн үржихүйн эрхийг хамгаалах, мэдлэг олгох үйл ажиллагаа явуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 80 хувиар дэмжигдлээ.

5 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй дараах саналыг танилцуулъя.

8. Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “сэтгэл зүйн эрүүл мэнд”

гэснийг “сэтгэц-зан үйл” гэж өөрчилж, 5.2.5 дахь заалтыг 5.6 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.6.Энэ хуулийн 5.1.5-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.6.1. нийгэм болон хүрээлэн байгаа орчноос үүдэлтэй сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах;

5.6.2. хүнийг амьдралын зөв хэв маягт сургах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “хөрсний бохирдол, ус хангамж, ариун цэвэр, хог хаягдлаас” гэснийг “уур амьсгалын өөрчлөлт, ус хангамж, хог хаягдал, хөрсний бохирдлоос” гэж, мөн заалтын дугаарыг “5.3” гэж тус тус өөрчилж, 5.2.4 дэх заалтыг 5.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.5.1. хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос урьдчилан сэргийлэх;

5.5.2. хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогод нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоох, тандалт, судалгаа хийх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1. халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг иргэн, гэр бүл, байгууллага, хамт олонд тулгуурлан зохион байгуулах;

5.2.2. нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.3. дахь заалтын дугаарыг “5.4” гэж, мөн заалтын “өвчлөл,” гэсний дараа “осол, гэмтэл,” гэж нэмж, 5.2.8 дахь заалтын дугаарыг “5.9” гэж, мөн заалтын “байгалийн гамшиг, нийтийг хамарсан ноцтой байдлын үед” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэж, “бэлэн байдлыг хангах;” гэснийг “, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа явуулна.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтын “дэмжих,” гэсний дараа “хамгаалах” гэж нэмж, мөн заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох” гэснийг 5.10.3 дахь заалт болгон өөрчилж, 5.3.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

“5.11.Энэ хуулийн 5.10.3-т заасан чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн

тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгана.

5.12.Энэ хуулийн 5.11-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах, эрх бүхий этгээдэд танилцуулахтай холбогдсон харилцааг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж санал хэлэх гишүүд байна уу. Одонтуяа гишүүн ажлын хэсгээс 7 зарчмын зөрүүтэй санал орж ирсэн. Салдангийн Одонтуяа дарга асуулт асууя.

С.Одонтуяа: Энэ нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий ийм зөвлөл гээд тэгэхээр ер нь эрүүл мэнд дээр чинь тулгамдсан асуудал, тулгамдаагүй асуудал гэж ангилах боломжгүй л дээ. Энэ чинь зүгээр ерөөсөө л эрсдэлт хүчин зүйлсүүд ямар байна. Найруулгыг нь жоохон засахгүй юм уу. Тулгамдсан асуудлыг хэлэлцэнэ гэхээр чинь яах юм. Их сонин л сонсогдоод байх юм. Тулгамдсан, тулгамдаагүй гэж.

П.Анужин: Ажлын хэсгийн ахлагч Сарангэрэл хариулт өгье.

Д.Сарангэрэл: Ерөнхий сайдын дэргэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр Үндэсний зөвлөл ажиллах юм. Яах вэ зарим гишүүдийн зүгээс ингээд Ерөнхий сайдын дэргэд олон зөвлөл байна гэж л байгаа юм. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн зөвлөл байх ёстой юм байгаа юм. Яагаад гэвэл Монгол Улсын 3,4 сая хүн амд бүгдэд нь хамааралтай. Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой асуудал учраас зөвлөл байх

учиртай гэж бид үзэж байгаа. Би ойлгож байгаа. Тэгэхээр Нийгмийн эрүүл мэндийн зөвлөл бол ийм тулгамдсан асуудлын үеэр хэлэлцэж, чиглэл шийдвэр гаргана уу гэхээс биш байнга нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл маань асуудал хэлэлцээд байхгүй л дээ. Энэ үүднээсээ нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед гэдэг юм уу, жилийн дараа тайлан юмаа хэлэлцэх байдаг юм уу энэ үед бид нар ажиллана уу гэхээс биш Үндэсний зөвлөл байн байн хуралдаад ингээд Засгийн газарт, Ерөнхий сайдад ачаалал болоод байхгүй л дээ. Тийм учраас тулгамдсан гэдгийг тодотгож оруулсан байгаа.

П.Анужин: Одонтуяа дарга хариулт хангалттай юу. Хариулт хангалттай гэж үзэж байна. Санал хураалт явуулна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 7 санал оруулж ирсэн байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг та бүхэндээ танилцуулъя.

Төслийн 6 дугаар зүйлийн гарчиг, 6.1-6.5, 6.10-6.12 дахь хэсгийг тус тус хасаж, 6.6 дахь хэсгийг 6 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл

6.1.Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий Нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Санал 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг 7 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

7.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сангийн ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

7.1.2. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах журмыг гамшигийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг 8 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэг

8.1. Төрийн захиргааны төв байгууллагууд нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. хүн амын эрүүл мэндийг дэмжих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх;

8.1.2. энэ хуулийн 14.1.3-т заасан чиг үүрэг;

8.1.3. Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг бодлого, шийдвэртээ тусгаж, хэрэгжүүлэх.

8.2. Энэ хуулийн 8.1-д заасан арга хэмжээний биелэлтийн тайланг жил бүрийн хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалтын “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэсний өмнө “шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж нэмж, мөн заалтын дугаарыг “12.1.7” гэж өөрчилж, 6.8 дахь хэсгийг 9 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.8.1-6.8.2 дахь заалтын дугаарыг “9.1.1-9.1.2” гэж, 6.8.4 дэх заалтын дугаарыг “9.1.3” гэж тус тус өөрчлөх:

“9 дүгээр зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг,

9.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“9.1.4. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжин ажиллаж байгаа байгууллагыг арга зүйгээр хангаж ажиллах;

9.1.5. Энэ хуулийн 8.2-т заасан тайланг нэгтгэн Зөвлөлд жил бүрийн дөрөвдүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь хэсгийг 10 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.13.1-6.13.4 дэх заалтын дугаарыг “10.1.1-10.1.4” гэж өөрчлөх:

“10 дугаар зүйл. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.13.2 дахь заалтын “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар” гэснийг “шаардлагатай санхүүжилтийг эрх бүхий байгууллагаар” гэж, 6.13.3 дахь заалтын “нөхцөлийг бүрдүүлэх” гэснийг “нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэж тус тус өөрчилж, 6.13.4 дэх заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа “, эрүүл мэндийн боловсрол олгох” гэж, мөн заалтын “оролцуулах” гэсний дараа “, урамшуулах” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“10.1.5. нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох асуудлаар эрүүл мэндийн байгууллага, ажилтныг дэмжиж ажиллах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасныг үндэслэн” гэснийг, “эрх зүйн байдал,” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн дугаарыг “11.2” гэж өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 80 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “7.1.2, 7.1.3-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын” гэснийг “11.1.2-т заасан байгууллагын” гэж, “батална” гэснийг “баталж, удирдлагыг Эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга томилж, чөлөөлнө” гэж тус тус өөрчилж, “дүрмийг” гэсний дараа “хүн амын төвлөрөл, газар нутгийн байршилыг харгалзан” гэж нэмж, мөн хэсгийн дугаарыг “11.3” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг түр хүлээж байгаарай. Санал хураалтыг цуцалъя. Чинбүрэн гишүүн санал хэлнэ. Зарчмын зөрүүтэй санал дээр.

Ж.Чинбүрэн: Би энэ дээр Чинзориг сайд байгаа учраас Сарангэрэл гишүүнээс, ажлын хэсгийн ахлагчаас асуумаар байгаа юм. Ер нь бид эмнэлгийн тусламж илүү нөгөө эмнэлгийн тусламжийн тухай хуулиараа илүү бие даасан тогтолцоо руу орж байгаа. Харин нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шууд босоо удирдлага илүү чухал. Яагаад гэвэл ерөөсөө командаар хийж байх ёстой. Олон түмэн зэрэг өвчлөх юм бол ерөөсөө энэ чинь шууд удирдлага дор ажиллах ёстой. Тэгэхлээр томилгооны асуудал сая ярьж байгаа. Энэ дээр энэ нөхцөл биелэх үү. Энийг ер нь юу гэж харж байгаа вэ. Ажлын хэсгийнхэн энэ дээр саналаа хэлээч.

П.Анужин: 4 номерын микрофонд ажлын хэсэг Баярболд дарга хариулт өгнө.

Д.Баярболд: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн дарга, Нийгмийн эрүүл мэндийн төвийн даргыг томилж, чөлөөлөх асуудал яригдаж байгаа. Тэгэхээр яг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж

үйлчилгээ гэж хувааж байгаа. Үүний адил аймаг, орон нутагт бол эмнэлгийн даргыг Засаг дарга томилж байгаа. Үүнтэй адилхан нийгмийн эрүүл мэндийн төвийн зэрэгцээ байдлаар яг эрүүл мэндийн газрын дарга нь томилдог байдлаар томьёолж оруулж байгаа. Тэгээд аймгийн эрүүл мэндийн газрын даргыг бол Засаг дарга томилж байгаа учраас яг нэгдсэн малгайнд тусламж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэг малгай дотроо явна гэдгээр энэ асуудлыг томьёолж орж ирсэн байгаа.

П.Анужин: Чинзориг сайд асуултад гүйцээж хариулъя.

С.Чинзориг: Чинбүрэн гишүүний санааг ойлгож байна. Ялангуяа нийгмийн эрүүл мэндийн асуудал, ялангуяа ноцтой байдал үүссэн үед босоо удирдлагатай байх нь зүйтэй юм уу гэж байгаа саналыг зарчмын хувьд би ойлгож байна. Гэхдээ ер нь нэг л зарчмаар байх нь зүйтэй л гэж би байгаа юм. Ер нь орон нутгийн удирдлага орон нутагтаа хүнээ томилдог байх энэ асуудлыг нь би дэмжээд хэвтээ удирдлагатай байх нь зүйтэй юм болов уу гэж л бодож байгаа юм. Ер нь цаашидаа бид нар Эрүүл мэндийн тухай хуулийг оруулж ирнэ. Эрүүл мэндийн тухай хуулиар томилгоотой холбоотой асуудлыг ч гэсэн нэг тийш нь шийдье гээд бодож байгаа. Манай эрүүл мэндийн тухай хуулиар бол сумын эрүүл мэндийн төвийн даргыг чинь бол 3 албан тушаалтан томилохоор юм явж байгаа юм байна лээ. Тэгээд өөрчлөлт орохоор тийм болчихсон юм байна лээ. Сумын эрүүл мэндийн газрын даргыг болохоор сумын дарга томилж болохоор, Аймгийн эрүүл мэндийн газрын дарга томилж болохоор бүр аймгийн Засаг дарга томилж болохоор эд нар гээд ийм 3 томилгоо хийж болохоор тийм хууль нөгөө нэмэлт, өөрчлөлт гэж явсаар тийм болчихсон. Тэгэхээр 1 мөсөн энийг ч гэсэн өөрчлөөд ер нь цаашидаа бид нар Аймгийн эрүүл мэндийн газрын даргыг бол яамнаас томилдог болъё. Гэхдээ улс төрийн албан

тушаалтан сайд бол Эрүүл мэндийн газрын даргыг томилох нь зохимжгүй байх. Салбар зөвлөлийнх нь саналыг үндэслээд тэгээд Төрийн нарийн ч юм уу манайх агентлаггүй учраас болохгүй байгаа юм. Тэгээд Төрийн нарийн томилдог байх юм уу тийм болгоё. Тэгээд сумын эмнэлгийн даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслээд, Аймгийн эрүүл мэндийн газрын дарга томилдог тогтолцоо руу оръё. Харин Нийгмийн эрүүл мэндийн төвийнхөө даргын Аймгийн эрүүл мэндийн газрын дарга нь томилоод явдаг байх нь зөв зүйтэй юм болов уу гэсэн ийм л саналаар бид нар асуудалд хандаж байгаа юм. Энэ зарчмаар явсан нь дээр байх. Тэгэхгүй бол аймгийн нэг бүтцийг сайд томилоод явах нь жаахан зовлонтой л юм байна лээ.

П.Анужин: Чинбүрэн гишүүн тодруулъя. 1 минут.

Ж.Чинбүрэн: Бас нөгөө удирдлага зохион байгуулалтын хувьд бид Си Ди Си буюу өвчний хяналт зохицуулах ийм төв байгуулах гээд байгаа шүү дээ. Үүнийхээ удирдлага доор орох уу үгүй юу. Яагаад гэхээр нийгмийн эрүүл мэндийн асуудлуудаа энэ хуулиараа бид нэг газар луу ингээд багцлаад бөөнд нь оруулчихсан. Тэгээд ийм босоо тогтолцоо яг өвчин судлалын тархалтын, хяналтын зохицуулалт хийхэд чухал байдаг учраас энэ дээр гишүүд нь анхаарч, анзаарна биз.

П.Анужин: Чинбүрэн гишүүн санал хэллээ. Ажлын хэсгийн гишүүд ч гэсэн байр сууриа хэллээ. Гишүүд ээ уучлаарай. Түрүүн 7 дугаар хэсэг дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас 7 дугаар зүйл дээр санал хураалт, ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй. Гишүүдээс 7 дугаар зүйлтэй холбоотой гишүүдээс санал байна уу. Байхгүй бол 7 дугаар зүйл дээр санал хураалт явуулъя. Санал хураалт байхгүй. Зарчмын зөрүүтэй санал гарч ирээгүй учраас.

Түрүүн Чинбүрэн гишүүнийг санал хэлэхийн өмнө 8 дугаар зүйлтэй холбоотой зүйл заалтыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт явуулъя гишүүд ээ. 80хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг 11.4 дэх хэсэг болгон, мөн хэсгийн “15.1.4, 15.1.7, 15.1.11-15.1.13-т” гэснийг “15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т” гэж, “нийгмийн эрүүл мэндийн” гэснийг “энэ хуулийн 11.1.3-т заасан” гэж тус тус өөрчилж, “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтныг ажиллуулж болно.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувиар уг санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“11.5.Энэ хуулийн 11.1.3-т заасан байгууллагын иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг 11.6 дахь хэсэг болгон “ажилтныг ажиллуулж болно” гэснийг “мэргэжилтэн ажиллуулна” гэж, 8.9 дэх хэсгийг 11.7 дахь хэсэг болгон мөн хэсгийн “7.1.1-7.1.5-д” гэснийг “11.1.1-11.1.4-т” гэж, “хоол зүйчид нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг, түслалцаа үзүүлнэ” гэснийг “хоол зүйч нарыг мэргэжил, арга зүйгээр хангана” гэж тус тус өөрчилж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай 11.8, 11.9 дэх хэсэг нэмэх:

“11.8.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасан байгууллага нь энэ хуулийн 11.1.4-

т заасан нэгж, албыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.”

11.9.Энэ хуулийн 5.10.1, 5.10.2, 5.10.3, 5.10.4-т заасан тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 80 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бодлого стратеги” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэл” гэж өөрчилж, “мэргэжил, удирдлага, арга зүйгээр хангах” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.1.2.энэ хуулийн 11.1.2, 11.1.3, 11.1.4, 11.1.5-д заасан байгууллага, нэгж, алба болон нийгмийн эрүүл мэндийн ажилтныг мэргэжил, арга зүйгээр хангах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ дээр алба болон гэж засах ёстой юм байна шүү. зөв бичгийн юугаар албыг болон биш алба болон гээд засчхаарай ажлын хэсэг. 70 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “өвчний хяналт, сэргийлэлтийн” гэснийг “энэ хуулийн 5.2-5.9-д заасан” гэж, “удирдан зохион байгуулах” гэснийг “зохион байгуулах, хянах, мэдээлэх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэж тус тус өөрчилж, 8.1.3 дахь заалтыг, 8.1.4 дэх заалтын “хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох,” гэснийг, мөн заалтын “, сургагч багш бэлтгэх, мэргэжил арга зүйгээр хангах” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Ажлын хэсгийн дарга сайн ажилласан. Техникийн алдаануудыг гаргасан байна. Шивэх засахдаа та нар анхаарлаа хандуул.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “эрдэм шинжилгээ, судалгааны

ажил хийх, холбогдох байгууллагад санал, зөвлөмж өгөх” гэснийг “үндэсний хэмжээний судалгаа хийх, зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах” гэж, 8.1.6 дахь заалтын “чиглэлээр үндэсний хэмжээнд лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэх” гэснийг “үндэсний хэмжээний лавлагаа лабораторитой байх” гэж, 8.1.7 дахь заалтын “урьдчилан сэргийлэх тарилга, биобэлдмэлийг” гэснийг “бүтээгдэхүүнийг” гэж, 8.1.8 дахь заалтын “чиглэлээр ажиллаж байгаа ажилтныг сургах, чадавхжуулах” гэснийг “ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах” гэж, 8.1.9 дэх заалтын “мэдээллийн санг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх” гэснийг “мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох, эмхэтгэн түгээх, эргэн мэдээлэх” гэж тус тус өөрчлөх гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Анхдагч хууль. Санал хураалт талдаа орж байна.80 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.4.1 дэх заалтыг тус тус хасах хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ. 70 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтын “бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар” гэж, 8.2.7 дахь заалтын “аюулгүй байдал алдагдахаас” гэснийг “аюулгүй байдал, шим тэжээлийн зохистой байдал алдагдсанаас шалтгаалсан өвчлөл, хордлогоос” гэж тус тус өөрчилж, 8.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.2.2.хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх орчны хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх,

урьдчилан сэргийлэх, хянах, холбогдох арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөн зохион байгуулах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын “нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэснийг өмнө “шуурхай удирдлагын нэгжтэй байх бөгөөд” гэж нэмж, 8.2.5 дахь заалтын “зонхилон тохиолдох” гэснийг, мөн заалтын “, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, мэдээлэх, хянах” гэснийг, 8.2.8 дахь заалтын “өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх,” гэснийг, мөн заалтын “, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх” гэснийг, 8.2.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“12.2.7.сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

12.2.8. нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт, үнэлгээ хийх;

12.2.9. нийгмийн эрүүл мэндийн лабораторийн үйл ажиллагаа эрхлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70 хувиар тус санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.4.3 дахь заалтын “халдварт болон халдварт бус зонхилон тохиолдох өвчний” гэснийг, 8.4.4 дэх заалтыг тус тус хасах:

“12.3.1.дархлаажуулалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

12.3.2.өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн

боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүд ээ. 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалтын “хүний эрүүл мэндэд” гэснийг “харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд” гэж, “зан үйл, эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах,” гэснийг “эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, тандалт, судалгаа хийх,” гэж өөрчилж, 8.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“12.4. Энэ хуулийн 11.1.4-т заасан нэгж, алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.4.1. тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтанд нийгмийн эрүүл мэндийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

12.4.2. тухайн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн чиглэлээр тандалт, судалгаа хийх;

12.4.3. тухайн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

8 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбоотой холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй. Зарчмын зөрүүтэй 3 саналаар санал хураалт явуулна.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.2.1 дэх заалтыг, 9.1.3 дахь заалтын “халдварт болон халдварт бус зонхилон тохиолдох өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх,” гэснийг тус тус хасаж, 9.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.3.нийгмийн эрүүл мэндийн асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтанд хандах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Төхөөрөмж сонин болчихлоо. Төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё. Нийт төхөөрөмж ажилласангүй. Хүчингүй болгоё. Нэг нь санал гаргая. Сарангэрэл дарга санал гаргая.

Д.Сарангэрэл: Саяын санал хураалт дээр тоног төхөөрөмж гацсан учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

П.Анужин: Нийт төхөөрөмж ажиллаагүй тул саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хүчингүй болгох санал 72,7 хувиар дэмжигдлээ. Санал хураалтыг явуулна. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“13.2.2.гэр бүл, хамт олны дунд эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшилийг бий болгоход нөлөөлөх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 72,7хувиар дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “тархвар судлалд” гэснийг “тандалт, судалгаа, тархвар судлалын

асуумжид” гэж, 9.2.6 дахь заалтын “нөлөөллийн талаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад мэдээлэх” гэснийг “нөлөөлөл, сэжигтэй тохиолдлын талаарх мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэх” гэж тус тус өөрчилж, 9.2.2 дахь заалтын “, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх дадал хандлагатай байх” гэснийг, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйл рүү орё. 10 дугаар зүйлтэй холбоотой гишүүдэд санал байна уу. Зарчмын зөрүүтэй санал байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 3 санал оруулж ирсэн байгаа. Танилцуулъя.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “зөвлөгөө” гэсний дараа “, мэдээлэл” гэж нэмж, мөн заалтын “хамгаалах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай” гэснийг “дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай” гэж өөрчилж, 10.1.3, 10.1.5, 10.1.7 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “орчин бүрдүүлэх” гэсний дараа “асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусган, хэрэгжүүлэх” гэж, мөн хэсэгт доор дурдсан агуулгатай заалт тус тус нэмэх:

“14.1.5.байгууллагын үйл ажиллагааны чиглэл, нутаг дэвсгэрийн онцлогт уялдуулан ажилтныг дархлаажуулалтад хамруулах арга хэмжээ авах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг 11.10 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.10.Хувийн хэвилийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, боловсролын сургалтын байгууллагад нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг ажиллуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Дараагийн зүйл рүү орж байна. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал оруулж ирсэн. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Олон нийтийн оролцоо

15.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нээлттэй ил тод байх бөгөөд түүнд олон нийтийн оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

15.2.Энэ хуулийн 11.1.1-11.1.4-т заасан байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

15.2.1. байнгын ажиллагаатай цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх, санал авах;

15.2.2. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын сайн дурын оролцоог хангах, урамшуулах.

15.3.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд олон нийтийн оролцоог хангах, сайн дурын ажилтныг урамшуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3 дахь хэсгийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

16.1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээлэл хүргэнэ.

16.2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй түгээнэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувиар санал хураалт дэмжигдлээ. Уг санал дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 2 санал ирүүлсэн байгаа. 2 саналыг уншиж танилцуулна.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1.1, 28.1.4, 28.1.5-д заасан эрх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бейсен гишүүний төхөөрөмжид ажлын хэсэг, Байнгын хороо анхаарал хандуулаарай. Ажиллахгүй байна гэж байна шүү. 63,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах,” гэснийг хасаж, мөн заалтын “дэмжлэг үзүүлэх” гэсний дараа “, мэргэжлийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд зааварчилгаа, зөвлөгөө өгөх” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“17.2.5. хүн амын эрүүл мэндэд аюул бүхий өвчин, хордлого, орчны сөрөг нөлөөллийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх.” Сана гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Яг нягтлаарай. Ажлын хэсэг Цоогий дарга анхаараарай. 63,6 хувиар санал хураалт дэмжигдлээ.

Төслийн 14 дүгээр зүйл зүйлтэй холбогдуулан асуулт, зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналыг та бүхэнд танилцуулъя.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “ажилтан” гэсний дараа “энэ хууль болон” гэж нэмж, 14.2 дахь хэсгийн “нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

15 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгийн зүгээс зарчмын зарчмын зөрүүтэй 2 санал ирүүлсэн.

Төслийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.4 дэх хэсгийг хасах:

“19.1. Энэ хуулийн 19.2-т зааснаас бусад нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

19.2. Холбогдох хуульд заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын болон Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс

санхүүжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ их чухал заалт. Сая би зарим гэдэг үгийг хаяж уншсан байна гэж байна. Зарим гэдэг үгийг нэмж тусгаарай.

Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, 15.5 дахь хэсгийн “тусламж, үйлчилгээний” гэсний дараа “төрөл” гэж нэмэх:

“19.4.Нийгмийн эрүүл мэндийн байгууллагын зарим тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 63,6хувиар дэмжигдлээ.

16 дугаар зүйл рүү оръё. 16 дугаар зүүтэй зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байхгүй бол ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 1 саналыг та бүхэнд танилцуулъя.

16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Иргэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хуулийн этгээд нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны талаар, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар” гэж өөрчилж, 16.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүд ээ, санал хураалтдаа анхаарлаа хандуулна уу. 54,5 хувиар дэмжигдлээ.

Төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй бол ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирсэн танилцуулъя.

Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “гэмт хэргийн шинжгүй” гэснийг “хуульд өөрөөр заагаагүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. 18 дугаар зүйлтэй холбогдуулж Эрүүл мэндийн сайд Чинзориг үг хэлж, асуулт асууна.

Түр хүлээж байгаарай. Эрүүл мэндийн сайд Чинзориг асуулт асууна.

С.Чинзориг: 18 дугаар зүйл гишүүд ээ, хуулийн хэрэгжих хугацаатай холбоотой заалт байгаа юм. Энийг би бодохдоо яах вэ, ажлын хэсэг бол 7 сарын 1 гэсэн байна лээ. Би бол ирэх оны 4 сарын 1-ээс байвал яасан юм бэ гэсэн бодолтой байгаа юм. Хууль батлагдах учраас гэж ярьж байгаад 2024 оны улсын төсөв дээр нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотойгоор 50 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудал бол улсын төсөв дээр тусчихсан юм. Тэгэхээр зохион байгуулалтын бүтцээ хийгээд, тэр өвчний хяналт тандалт сэргэлтийнхээ төвийг байгуулах юмнуудаа хийгээд, орон нутгийн бүтцийг нь байгуулж өгөөд, тэгээд үйлчилгээг хуулиа 4 сарын 1-ээс хэрэгжүүлбэл яасан юм бэ гээд.

2 дахь асуудал нь Засгийн газар дээр ярьж байгаад Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний тухай тогтоол гаргаад, одоо салбар хоорондын уялдаатай асуудал гээд ингээд холбогдох сайд нартай хамтарсан иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, төлөвлөгөө эд нар батлаад явж байгаа юм. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхтэй холбоотойгоор төсөв дээр 5 тэрбум төгрөг тусгачихсан юм 2024 оны төсөв дээр. Тэгэхээр ингээд төсвийнх нь боломжууд орчихсон учраас би заавал 7 сарын 1 гэхгүйгээр 4 сарын 1-ээс хуулиа хэрэгжүүлээд явбал яасан юм юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм. Тэгээд энийг манай Байнгын хороо,

ажлын хэсэг анхаарч үзвэл яасан юм. Тийм боломж байх уу Сарангэрэл дарга аа. Би бол тэр төсөв дээр санхүүжилтийн асуудал нь бас зохих хэмжээгээр туссан.

2 дугаарт тэр өвчний сэргийлэлт, хяналт сэргийлэлтийн төв байгуулна гэдэг бол цоо шинээр бүтэц, орон тоо байгуулахгүй шүү дээ. Одоогийн байгаа Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийг тэр хяналт, тандалт сэргэлтийн төв болгоно. Дээр нь ЗООНОЗ, ХӨСҮТ мөн нөгөө эрүүл мэндийн хөгжлийн төвийн зарим нэг чиг үүргийг нь тэр нийгмийн эрүүл мэндийн төвтэй нэгтгээд, тэгээд тэр өвчний хяналт тандалт сэргэлтийн төв байгуулаад ингээд явчих бололцоотой. Тийм учраас төсөв санхүүгийн асуудлын хүндрэл гарахгүй учраас би хугацааг нь 4 сарын 1 гээд ингээд хуулиа хэрэгжүүлээд явбал яасан юм саналтай байгаа. Энийг Байнгын хорооны гишүүн анхаарч авч үзээч гэсэн санал байна.

П.Анужин: Чинзориг сайдын саналыг ажлын хэсгийн ахлагч Сарангэрэл дарга өчигдөр яг энэ байдлаар нь тайлбарлаж санал оруулсан. Тийм учраас хуулийн ажлын хэсгийн ахлагч мөн салбарын сайд нь энэ санал дээр санал нэгдэж байгаа учраас гаргасан саналынх нь томъёоллоор явах нь зүйтэй гэж үзэж байна. Саналын томъёоллын уншиж танилцуулъя.

Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Энэ хуулийг 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 54,5 хувиар дэмжигдлээ.

Гишүүд ээ санал хураалтдаа анхаараарай. Найруулгын саналаар санал хураалт явуулна.

Төсөлд зүйл, хэсэг, заалт нэмэх, хасах саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эилэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ, саналаа өгөөрэй. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн хэлсэн найруулгын шинж чанартай санал руу орж байна. Зарчмын зөрүүтэй санал хураагдаж дууслаа.

Найруулгын саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа, 5.2.3 дахь заалтын “хадгалах” гэсний дараа, 5.2.7 дахь заалтын “тандах” гэсний дараа “үйл ажиллагаа явуулна.” гэж, 6 дугаар зүйлийн 6.13.3 дахь заалтын “нутаг дэвсгэрийн” гэсний өмнө “харьяа” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.4, 8.4.5 дахь заалтын “ноцтой байдлын” гэсний дараа “үеийн” гэж, “арга хэмжээг” гэсний дараа “авч” гэж, 8.2.8 дахь заалтын “эрүүл мэндийн” гэсний өмнө “хүн амд” гэж, 8.9 дэх хэсгийн “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “батална” гэсний өмнө “хамтран” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн байдал” гэснийг “эрүүл мэнд” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “нөлөөлөх” гэснийг “үзүүлэх” гэж, “хариу арга хэмжээг” гэснийг “холбогдох арга хэмжээ” гэж, 3.1.7 дахь заалтын “тодорхойлж” гэснийг “тогтоож” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “олон хувилбартай байх” гэснийг “хэлбэр үл харгалзах” гэж, 4.1.7 дахь заалтыг “олон нийтийн, сайн дурын ажилтны оролцоог хангах” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.3, 5.2.7, 5.2.8 дахь заалтын “төрөлд” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд”

гээж, 5.2.2 дахь заалтын “өвчлөл” гэснийг “өвчин эмгэг” гэж, 5.3.1 дэх заалтын “мандалт, судалгаа” гэснийг “мандах, судлах” гэж, 5.3.5 дахь заалтын “түнишлэл, хамтын ажиллагаа” гэснийг “оролцоо, хамтын ажиллагааг хангах” гэж, 6 дугаар зүйлийн 6.8.2 дахь заалтын “бодлого, хөгжлийн чиг хандлага,” гэснийг “хөгжлийн бодлого, чиглэлийг болон” гэж, “тодорхойлох” гэснийг “тодорхойлж, хэрэгжүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.4 дэх хэсгийн “эрх үүргийг” гэснийг “чиг үүргийг” гэж, 8.2.7 дахь заалтын “тодорхойлох” гэснийг “тогтоох” гэж, 8.4.3 дахь заалтын “зохион байгуулах” гэснийг “зохион байгуулж, хэрэгжүүлэх” гэж, 8.4.5 дахь заалтын “бэлэн байдал” гэснийг “бэлэн байдлыг хангах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “хуулийн” гэснийг “хууль тогтоомжийн” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “боломж бүрдүүлэх” гэснийг “боломжоор хангах” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрхтэй” гэснийг “эрх эдэлнэ” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “ажилтанд урамшуулал олгох” гэснийг “ажилтныг урамшуулах” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “ангилал,” гэснийг “ангилаар болон” гэж тус тус өөрчлөх;

3. Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль эрх зүйн” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтын “хөдөлмөр эрхлэгч” гэснийг, 5.2.7 дахь заалтын “судлах,” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.4, 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын “амьдрах” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.13.4, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “нийгмийн” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтын “, мэдлэг” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “энэ хуулийн 3.1.11-д заасан” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “арга болон” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний Үндсэн хуультай холбоотой зарчмын зөрүүтэй санал хураалтаар санал хураалт явуулж дууслаа. Хамт өргөн мэдүүлсэн хуулиудтай холбоотой зарчмын зөрүүтэй саналуудыг танилцуулж санал хураалт явуулна.

Хамгийн эхэнд нь Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн талаар зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцүүлэх байгаа.

1 дүгээр зүйлтэй холбоотойгоор ажлын хэсгээс 2 санал оруулж ирсэн. Унишиж танилцуулъя.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, 1 дүгээр зүйлийн дугаарыг “2” гэж өөрчлөх:

“1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.26 дахь заалт нэмсүгэй:

“3.1.26. “нийгмийн эрүүл мэндийн ажилтан” гэж Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3.1.17-д заасан мэргэжилтнийг.”” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн “29.5 дахь” гэсний өмнө “29.2 дахь хэсгийн “эмнэлгийн мэргэжилтэн,” гэсний дараа “нийгмийн эрүүл мэндийн ажилтан,” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийн “24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх хэсэгт “нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, арга хэмжээ болон гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дээгдэлтийн

үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэснийг “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшигийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” гэж” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.6.4.хуульд өөрөөр заагаагүй бол нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гамшигийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэндийн тухай хууль тогтоомж” гэснийг “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” гэж өөрчилж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийн “энэ хууль” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйл рүү орж байна. Төслийн 3 дугаар зүйрлэлтэй зүйлтэй холбоотой гишүүдээс зарчмын зөрүүтэй санал байна уу. Асуулт байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал ирүүлсэн. Саналыг танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн “13 дугаар” гэсний өмнө “7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг,” гэж нэмэх. Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төсөлд шинэ зүйл нэмсэнтэй уялдуулан төслийн дугаарлалтыг нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн дагасан хуультай холбоотой зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

Боловсролын ерөнхий хууль батлагдсантай холбогдуулаад тухайн заалтууд маань хуульдаа тусгагдсан учир ажлын хэсгээс төслийг хууль санаачлагчид нь буцаах саналыг гаргая гэсэн байгаа. Хууль санаачлагчид нь буцаах саналаар санал хураалт явуулна.

Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар танилцуулна.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зөрчлийн хуулийн 1 дүгээр зүйл. Байхгүй байна. Ажлын хэсгээс 1 санал оруулж ирсэн. Танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “6.29 дэх хэсгийг” гэснийг “6.31 дэх зүйл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу. Асуулт асуух гишүүд байна уу. Байхгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 1 дүгээр зүйлийн “6.8 дугаар зүйлийн “6.28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэсний дараа “6.29 дүгээр зүйл,” гэснийг “1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “7.6 дугаар зүйлийн 9 дэх

хэсэг,” гэсний өмнө “6.31 дүгээр зүйл,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх 2 тусдаа хууль байгаа. Хууль тус бүр дээр зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явууллаа.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал ирсэн. Санал хураалт явуулна.

Санал хэлж, асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Ажлын хэсгээс 1 санал ирсэн байгаа танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “нийтийг хамарсан халдварт өвчний” гэснийг хасаж, “нийгмийн эрүүл мэндийн” гэсний өмнө “дэгдэлт,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хороогоор анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөж байна. 10 цагаас эхлүүлэн хуралдсан Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаандаа идэвхтэй оролцсон нийт гишүүддээ Байнгын хорооны гишүүддээ талархал илэрхийлье ээ. Баярлалаа. Өнөөдрийн хуралдаан.

**Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ